



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар

1/09

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 2.1.2, 4.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Салбарын ангиллын дугаар олгох, хэрэглэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Салбарын ангиллын дугаар олгосонтой холбогдуулан Дипломат төлөөлөгчийн газруудын тамгыг шинээр хийлгэн хүргүүлэх ажлыг 2021 оны 06 дугаар сарын 01-ний дотор хийж гүйцэтгэхийг Төрийн захиргааны удирдлагын газрын захирал (С.Золжаргал)-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Индекс, цахим шуудангийн хаяг шинэчлэн батлах тухай” Гадаад харилцааны сайдын 2016 оны А/02 дугаар тушаал, “Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай” Гадаад харилцааны сайдын 2016 оны А/32 дугаар тушаал, “Индекс, цахим шуудангийн хаяг батлах тухай” Гадаад харилцааны сайдын 2019 оны А/06 дугаар тушаал, “Индекс, цахим шуудангийн хаяг батлах тухай” Гадаад харилцааны сайдын 2019 оны А/66, А/110 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын захирал (С.Золжаргал), ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын ерөнхий нарийн бичгийн дарга (С.Уянга), Хөрөнгө оруулалтын судалгааны төвийн захирал (С.Ганхуяг), Дипломат төлөөлөгчийн газруудын тэргүүн нарт үүрэг болгосугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

101210029

САЛБАРЫН АНГИЛЛЫН ДУГААР ОЛГОХ, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Гадаад харилцааны яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж /цаашид “яамны нэгж” гэх/, харьяа байгууллага, хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар /цаадид “ДТГ” гэх/-т салбарын ангиллын дугаар шинээр болон сэргээн олгох, бүртгэх, дугаарыг хэрэглэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Салбарын ангиллын дугаар олгох

2.1. Салбарын ангиллын дугаар нь яам, харьяа байгууллага, ДТГ гэсэн түвшинтэй байна.

- 1-Гадаад харилцааны яам
- 2-Харьяа байгууллага
- 3-ДТГ

2.2. **Яамны нэгж**- Засгийн газрын тогтоолд зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн бичигдсэн дарааллыг баримтлан дараалуулж дугаарлана /хавсралт-1/.

2.3. Тогтоолд нэр заагдаагүй ч тамга, хэвлэмэл хуудас хэрэглэх эрх бүхий, эсхүл цахим шуудангийн хаягтай нэгжид ангиллын дугаар олгоно. Дугаарыг яамны нэгжийн сүүлийн дугаараас дараалуулан олгоно.

2.4. **Харьяа байгууллага**- Гадаад харилцааны яаманд харьяалуулсан шийдвэрийн огноог баримтлан дараалуулж дугаарлана /хавсралт-2/.

2.5. **ДТГ**-Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас олгосон тамга хийлгэх зөвшөөрлийн огноог баримтлан дараалуулж дугаарлана. Энэхүү дугаарт ДТГ байгуулагдсан шийдвэрийн огноог баримтлахгүй /хавсралт-3/.

2.6. Харьяа байгууллага, ДТГ-ын салбарын ангиллын дугаар нь дахин давтагдахгүй байна.

Гурав. Бүртгэл үйлдэх, хяналт тавин ажиллах

3.1 ГХЯ-ны хэвлэмэл хуудас хариуцсан ажилтан нь яамны нэгж, харьяа байгууллагын дугаарын бүртгэлийг хөтлөн холбогдох ажилтнуудад мэдэгдэн хяналт тавьж ажиллана /хавсралт-4/.

3.2. ГХЯ-ны тамга, тэмдэг түших эрх бүхий ажилтан нь ДТГ-ын дугаарын бүртгэлийг хөтлөн холбогдох ажилтнуудад мэдэгдэн хяналт тавьж ажиллана /хавсралт-5/.

3.3. Байгууллага нь яаманд харьяалагдахгүй болсон тохиолдолд дугаарыг хэвээр хадгалан үлдээх ба дахин харьяалагдах болсон тохиолдолд хуучин дугаарыг сэргээн олгож бүртгэлд холбогдох тэмдэглэгээг хийнэ.

3.4. ДТГ хаагдсан тохиолдолд дугаарыг хэвээр хадгалан үлдээх ба сэргээн ажиллуулах шийдвэр гарч үйл ажиллагаа нь эхлэх үед хуучин дугаарыг сэргээн олгож, бүртгэлд холбогдох тэмдэглэгээг хийнэ.

3.5. Тухайн ДТГ-ын түвшин, байршил, байршиж буй хотын нэр өөрчлөгдсөн ч үйл ажиллагаа нь үргэлжилж байгаа тохиолдолд дугаарыг өөрчлөхгүй. Бүртгэлд түвшин, байршлын өөрчлөлтийн тэмдэглэгээг хийнэ.

3.6. Энэ журмын 3.1, 3.2-т заасан бүртгэл хариуцсан ажилтны албан тушаалын тодорхойлолтод энэ чиг үүргийг тусган нэгжийн удирдлага бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

3.7. Энэ журмын 3.1, 3.2-т заасан бүртгэл хариуцсан ажилтан нь мэдээллийг үнэн зөв бүртгэж дугаарын алдаа гаргахгүй ажиллах үүрэгтэй ба салбарын ангиллын дугаарын бүртгэлийн мэдээллийг жил бүр Гадаад харилцааны төв архивт шилжүүлэх үүрэг хүлээнэ.

Дөрөв. Салбарын ангиллын дугаарыг хэрэглэх

4.1. Салбарын ангиллын дугаарыг дараах зориулалтаар хэрэглэнэ.

- Баримт бичгийн бүртгэлийн дугаарын өмнө (08/...);
- Цахим шуудангийн бүртгэлийн дугаарын өмнө (e/08/21...);
- Яамны нэгжийн цахим шууданд (dep01);
- Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад (08/01);
- Хэвлэмэл хуудасны индекст (3010121000);
- ДТГ-ын тамганы дардаст;

4.2. ДТГ-ын тамганы дардасны дугаар нь тухайн ДТГ-ын салбарын ангиллын дугаартай адил байна.

САЛБАРЫН АНГИЛЛЫН ДУГААР

| д/д | 1. Гадаад харилцааны яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэр | Дугаар |
|-----|--|--------|
| 1 | 2 | 3 |
| 1. | Бодлого төлөвлөлтийн газар | 1-01 |
| 2. | Хөрш орнуудын газар | 1-02 |
| 3. | Европын газар | 1-03 |
| 4. | Ази, Номхон далайн орнуудын газар | 1-04 |
| 5. | Америк, Ойрхи дорнод, Африкийн газар | 1-05 |
| 6. | Олон талт хамтын ажиллагааны газар | 1-06 |
| 7. | Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар | 1-07 |
| 8. | Төрийн захиргааны удирдлагын газар | 1-08 |
| 9. | Олон улсын гэрээ, эрх зүйн газар | 1-09 |
| 10. | Консулын газар | 1-10 |
| 11. | Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газар | 1-11 |
| 12. | Дипломат ёслолын газар | 1-12 |
| 13. | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар | 1-13 |
| 14. | Гадаад харилцааны төв архив | 1-14 |
| 15. | Санхүү, эдийн засгийн хэлтэс | 1-15 |

| д/д | 2. Харьяа байгууллагын нэр | Дугаар | Харьяа болсон огноо |
|-----|--------------------------------------|--------|---------------------|
| 1 | 2 | | 3 |
| 1. | ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс | 2-01 | 2012.12.15 |
| 2. | Хөрөнгө оруулалтын судалгааны төв | 2-02 | 2017.09.13 |

| д/д | 3. Дипломат төлөөлөгчийн газрын нэр | Дугаар | Тамганы дугаар |
|-----|---|--------|----------------|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яам | 3-01 | 01 |
| 2. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Элчин сайдын яам | 3-02 | 02 |
| 3. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад суугаа Элчин сайдын яам | 3-03 | 03 |
| 4. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Элчин сайдын яам | 3-04 | 04 |
| 5. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Элчин сайдын яам | 3-05 | 05 |
| 6. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод суугаа Ерөнхий консулын газар | 3-06 | 06 |
| 7. | Монгол Улсаас Унгар Улсад суугаа Элчин сайдын яам | 3-07 | 07 |
| 8. | Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа Элчин сайдын яам | 3-08 | 08 |
| 9. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Элчин сайдын яам | 3-09 | 09 |
| 10. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа Элчин сайдын яам | 3-10 | 10 |
| 11. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Элчин сайдын яам | 3-11 | 11 |
| 12. | Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газар | 3-12 | 12 |
| 13. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Элчин сайдын яам | 3-13 | 13 |
| 14. | Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Элчин сайдын яам | 3-14 | 14 |
| 15. | Монгол Улсаас Женев дэх НҮБ-ын төв болон бусад олон улсын байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газар | 3-15 | 15 |
| 16. | Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суугаа Элчин сайдын яам | 3-16 | 16 |
| 17. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Элчин сайдын яам | 3-17 | 17 |
| 18. | Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Эрхүү хотод суугаа Ерөнхий консулын газар | 3-18 | 18 |
| 19. | Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яам | 3-19 | 19 |
| 20. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Элчин сайдын яам | 3-20 | 20 |
| 21. | Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсад суугаа Элчин сайдын яам | 3-21 | 21 |
| 22. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Элчин сайдын яам | 3-22 | 22 |
| 23. | Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Улаан-Үд хотод суугаа Ерөнхий консулын газар | 3-23 | 23 |
| 24. | Монгол Улсаас Бельгийн Хаант Улсад суугаа Элчин сайдын яам | 3-24 | 24 |
| 25. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Элчин сайдын яам | 3-25 | 25 |
| 26. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Элчин сайдын яам | 3-26 | 26 |

| 1 | 2 | 3 | 4 |
|-----|--|------|----|
| 27. | Монгол Улсаас Канад Улсад суугаа Элчин сайдын яам | 3-27 | 27 |
| 28. | Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа Элчин сайдын яам | 3-28 | 28 |
| 29. | Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Кызыл хотод суугаа Ерөнхий консулын газар | 3-29 | 29 |
| 30. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Элчин сайдын яам | 3-30 | 30 |
| 31. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Элчин сайдын яам | 3-31 | 31 |
| 32. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрээн хотод суугаа Консулын газар | 3-32 | 32 |
| 33. | Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Элчин сайдын яам | 3-33 | 33 |
| 34. | Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа Элчин сайдын яам | 3-34 | 34 |
| 35. | Монгол Улсаас Кувейт Улсад суугаа Элчин сайдын яам | 3-35 | 35 |
| 36. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хонконг хотод суугаа Ерөнхий консулын газар | 3-36 | 36 |
| 37. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Элчин сайдын яам | 3-37 | 37 |
| 38. | Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсын Сан Франциско хотод суугаа Ерөнхий консулын газар | 3-38 | 38 |
| 39. | Монгол Улсаас Япон Улсын Осака хотод суугаа Ерөнхий консулын газар | 3-39 | 39 |
| 40. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суугаа Элчин сайдын яам | 3-40 | 40 |
| 41. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотод суугаа Ерөнхий консулын газар | 3-41 | 41 |
| 42. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсын Пусан хотод суугаа Консулын газар | 3-42 | 42 |
| 43. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанхай хотод суугаа Ерөнхий консулын газар | 3-43 | 43 |
| 44. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суугаа Элчин сайдын яам | 3-44 | 44 |
| 45. | Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Манжуур хотод суугаа Консулын газар | 3-45 | 45 |

Хавсралт-4

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ДУГААРЫН БҮРТГЭЛ

| Дугаар | Байгууллагын нэр | Харьяа болсон огноо | Шийдвэр | Харьяалагдахгүй болсон огноо | Шийдвэр | Дугаарыг сэргээсэн огноо | Шийдвэр |
|--------|------------------|---------------------|---------|------------------------------|---------|--------------------------|---------|
| | | | | | | | |
| | | | | | | | |

ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУДЫН ДУГААРЫН БҮРТГЭЛ

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|--------|---|--------------------------------|---|------------------------------------|---|----------------------|---|-------------------------------|---|---------|---|--------------------------------|---|--------|---|------------------|----|---------|----|---------|----|-------------------|----|---------|----|---------------|----|----------------------------------|
| 1 | дугаар | 2 | Дипломат төлөөлөгчийн назар | 3 | Тамганы зөвшөөрөл олгосон огноо | 4 | Албан бичгийн дугаар | 5 | Байгуулах шийдвэрийн огноо | 6 | Шийдвэр | 7 | Үйл ажиллагаа эхэлсэн огноо | 8 | Түвшин | 9 | Түвшний өөрчлөлт | 10 | Шийдвэр | 11 | Байршил | 12 | Байршлын өөрчлөлт | 13 | Шийдвэр | 14 | Хаардсан эсэх | 15 | Үйл ажиллагааг сэргээсэн эсэх |
|---|--------|---|--------------------------------|---|------------------------------------|---|----------------------|---|-------------------------------|---|---------|---|--------------------------------|---|--------|---|------------------|----|---------|----|---------|----|-------------------|----|---------|----|---------------|----|----------------------------------|

ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУДЫН ДУГААРЫН БҮРТГЭЛ

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|--------|---|-----------------------------|---|---------------------------------|---|----------------------|---|----------------------------|---|---------|---|-----------------------------|---|--------|---|------------------|----|---------|----|---------|----|--------------------|----|---------|----|---------------|----|-------------------------------|
| 1 | дугаар | 2 | Дипломат төлөөлөгчийн назар | 3 | Тамганы зөвшөөрөл олгосон огноо | 4 | Албан бичгийн дугаар | 5 | Байгуулах шийдвэрийн огноо | 6 | Шийдвэр | 7 | Үйл ажиллагаа эхэлсэн огноо | 8 | Түвшин | 9 | Түвшний өөрчлөлт | 10 | Шийдвэр | 11 | Байршил | 12 | Байршлийн өөрчлөлт | 13 | Шийдвэр | 14 | Хаалдсан эсэх | 15 | Үйл ажиллагааг саргээсэн эсэх |
|---|--------|---|-----------------------------|---|---------------------------------|---|----------------------|---|----------------------------|---|---------|---|-----------------------------|---|--------|---|------------------|----|---------|----|---------|----|--------------------|----|---------|----|---------------|----|-------------------------------|